

ХЭД ХЭДЭН ГЭМТ ХЭРЭГТ ЯЛ ОНОГДУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

IMPROVING LEGAL REGULATION ON PUNISHMENTS FOR CONCURRENCE OF CRIMES



Д.БАЯРСАЙХАН

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, хууль зүйн доктор, профессор

BAYARSAIKHAN D.

Ph.D, Professor, Head of the Criminal Justice Department, School of Law, National University of Mongolia



Б.БАТСҮХ

Нийслэлийн Авто замын газрын хуулийн зөвлөх, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант

BATSUKH B.

Legal counsel, Road department, Implementing Agency of Capital governor, Master's degree student, School of Law, National University of Mongolia

Товч агуулга: Эрүүгийн хууль нь Ардчилсан нийгмийн онцгой чухал хэсэг билээ. Эрүүгийн хууль, ялангуяа ял шийтгэлийн зохицуулалт хүний эрх, эрх чөлөөтэй холбогддог учир уг зохицуулалт эрх зүйн зарчим болон Олон улсын эрх зүйд нийцсэн байх шаардлагатай. Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах эрх зүйн зохицуулалт нь “хэрэв хэн нэг этгээд хоёр болон түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шүүх гэмт хэрэг тус бүрт ял оногдуулсны дараа тэдгээрийг нэмж нэгтгэнэ” гэсэн агуулгатай байдаг. Энэхүү өгүүлэл хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах Монгол Улсын зохицуулалт болон нөхцөл байдал, гадаад улсын болон олон улсын зохицуулалт, цаашлаад энэхүү зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлахад чиглэгдсэн болно.

Abstract: Criminal code is the special and important part of Rule of Law in Democratic society because criminal code, especially, punishment provision limits human rights and dignity, it shall be in accordance with common principle of Rule of Law and International law norms. Legal regulation of punishments for concurrence of crimes means when an offender has been convicted of two or more crimes in one act, the court must pronounce a penalty for each individual crime and then impose a consolidated punishment. This research work aims to research the Mongolian condition and legal regulation of punishments for concurrence of crimes, Foreign and International regulation, and furthermore, way to improve Mongolian regulation of punishments for concurrence of crimes.

Өнөөдөр шүүхийн эрх мэдлийн хүрээнд шинэтгэл явагдаж, нийгэмд олон олон шинэ үзэгдэл, шинэ төрлийн харилцаа, шинэ төрлийн гэмт хэрэг гарч байгаагаар холбогдуулан түүнийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс Үндсэн хуулинд нийцүүлэн гаргасан зарим нэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шинэчлэн найруулах, хуулийг өөрчилж, шинэчлэн батлах ажиллагаа эрчимтэй явагдаж байгаа билээ.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийг өөрчилж шинэчлэх явцад юуны өмнө ялын зорилго, агуулгыг нийгмийн шударга ёс, шүүх эрх мэдлийн зарчим, чиг хандлагын хүрээнд эрүүгийн эрх зүйн салбарт хийгдэж буй өөрчлөлт шинэчлэлтийн тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй хүмүүнлэг хандлагад нийцүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Түүнчлэн ял оногдуулах институтын хүрээнд ялыг нэгтгэх буюу хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлын хувьд хэм хэмжээний зөрчилдөөнтэй, хийдэлтэй заалтууд цөөнгүй байгаа нь практик судалгаагаар тогтоогдсон юм.

1. Шүүхийн практикт хийсэн судалгаа

Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлыг шүүхийн практикт хэрхэн хэрэглэдэг, эрх зүйн зохицуулалтын хүрээнд хийдэлтэй, зөрчилдөөнтэй ямар заалтууд байгаа зэргийг судлан үзэхдээ:

1. Шүүхийн статистикийн тоо баримтууд /сүүлийн 4 жилийн байдлаар/

2. Шүүхийн шийтгэх тогтоолуудад дүн шинжилгээ хийх

3. Хэм хэмжээний зөрчилдөөнтэй заалтуудыг илрүүлж улмаар уг хэм хэмжээг хэрэглэснээр хүний эрхийг зөрчих болон ял завшуулж буй тодорхой тохиолдлуудад дүгнэлт хийх зэргээр судалгааны ажлыг хийлээ. Эдгээр тус бүрээр авч үзвэл:

Шүүхийн статистикийн тоо баримтад хийсэн судалгаа:

Шүүхийн статистикийн нэгдсэн дүнгээс үзэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий анги /ЭХЕА/-ийн 57 дугаар зүйл буюу хэд хэдэн гэмт хэрэг ял оногдуулах асуудлын хүрээнд нэгдсэн тоо баримтыг тусгайлан хөтөлдөггүй ажээ. Иймд гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлэгчдийн тоо мэдээлэлд тулгуурлан гэмт хэргийн гаралт, ажлын ачаалал ихтэй Дархан-Уул аймгийн сум дундын шүүх, гэмт хэргийн гаралт дунд зэрэг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүх, Булган аймаг дахь сум дундын шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын шүүх, гэмт хэргийн гаралт бага Өмнөговь аймаг дахь сум дундын шүүх, Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхүүдийн тухайн үеийн хэргийн баримтыг судалж, эдгээр шүүхүүд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57, 58 дугаар зүйлүүдээр хэдэн хүнд ял шийтгэл оногдуулсан, хуулийн энэ зохицуулалтыг хэрхэн хэрэглэсэн талаар судаллаа.

Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулсан байдлыг судлан үзэхэд:

Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргүүдийн шүүхийн шийдвэрлэсэн нийт хэрэг, ЭХ-ийн 57-р зүйлийг журамлан шийдвэрлэсэн хэргүүдээс харахад

2011 онд нийт 795 хэрэг шийдвэрлэсний 57 хэрэг буюу 7.1 хувийг ЭХЕА-ийн 57-р зүйлийг журамлан ял оногдуулсан байна.

2012 онд нийт 857 хэрэг шийдвэрлэсний 62 хэрэг буюу 7.2 хувийг ЭХЕА-ийн 57-р зүйлийг журамлан ял оногдуулсан байна.

2013 онд нийт 845 хэрэг шийдвэрлэсний 52 нь буюу 6.1 хувьд нь ЭХЕА-ийн 57-р зүйлийг журамлан ял оногдуулсан.

2014 онд нийт 849 хэрэг шийдвэрлэсний 65 хэрэг буюу 7.6 хувийг ЭХЕА-ийн 57-р зүйлийг журамлан ял оногдуулсан.

Энэ нь ЭХЕА-ийн 57-р зүйлд заасан Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах

асуудал шүүхийн практикт түгээмэл хэрэглэгддэг болохыг харуулж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж үзэхэд:

Дээрх шүүхүүдийн практикийг судалж үзэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйл буюу хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял оногдуулах журмыг хэрэглэж хэвшсэн мэт байгаа боловч энэ зүйл, заалтуудыг өөр өөрөөр хэрэглэж, хүний эрхийг зөрчих, ял завшуулах дутагдал гарсаар байгаа мөн давж заалдах шатны шүүхээс хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр хэрэг өөрчлөлт орох, хүчингүй болгох асуудал цөөнгүй байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 57, 58 дугаар зүйлүүдийн хэм хэмжээ өөр хоорондоо зөрчилдөөнтэй, хуулиар зохицуулаагүй асуудлууд багагүй байгааг харуулж байна. Жишээ нь: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2009 оны 07 сарын 16-ны өдрийн 217 тоот шийтгэх тогтоолоор шүүгдэгч П.Э нарт холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ “Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 58 дугаар зүйлийн 58.1-д зааснаар энэ тогтоолоор оногдуулсан хорих ялд тус шүүхийн 2007 оны 01 сарын 24-ний өдрийн 40 дүгээр шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн 5 жил 5 сарын хорих ялын зарим болох 2 жилийн хорих ялыг нэмж нэгтгэн бүгд биечлэн эдлэх ялыг 500000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 12 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар хорих ялаар шийтгэсэн¹,

Дархан Уул аймаг дахь Сум дундын шүүхийн 2010 оны 02 сарын 23-ны өдрийн 51 тоот шийтгэх тогтоолоор шүүгдэгч Э.П-д Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 58 дугаар зүйлийн 58.5-д заасныг баримтлан 6 сарын баривчлах ялаар шийтгэсэн²,

Дорноговь аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн 2010 оны 10 сарын 05-ны өдрийн 106 тоот шийтгэх тогтоолоор У.Т-д Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-т зааснаар энэ тогтоолоор оногдуулсан 3 жил 6 сарын хорих ял дээр тус шүүхийн 2008 оны 10 сарын 24-ны өдрийн 80 тоот шийтгэх тогтоолоор оногдуулсан 2 жил 4 сарын хорих ялаас эдлээгүй үлдсэн 10 сар 29 хоногийн тэнсэн суллагдсан хорих ялаас заримыг буюу 6 сарыг нэмж нэгтгэн бүгд 4 жилийн хорих ялаар, шүүгдэгч У.Т-д энэ тогтоолоор оногдуулсан 3 жилийн хорих ял дээр тус шүүхийн 2010 оны 05 сарын 4-ний өдрийн 60 тоот шийтгэх тогтоолоор оногдуулсан 5 жил 1 сарын хорих ялаас эдлээгүй үлдсэн 4 жил 9 сарын хорих ялаас заримыг буюу 4 жилийн хорих ялыг нэмж нэгтгэн бүгд 7 жилийн хорих ялаар шийтгэсэн³ байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд дүгнэлт хийж үзэхэд дараахь зөрчил, дутагдлууд илэрч байна.

Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь заалтыг хэрэглэх журам нь “ Ялтан шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдвол энэ зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна. Ингэж шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хагас эдэлсэн ялыг оруулан тооцно.” гэж зохицуулсан байхад Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д “Шүүхийн шийтгэх тогтоол гарсаны дараа буюу оногдуулсан ялыг бүрэн эдэлж дуусахын өмнө гэмт хэрэг шинээр үйлдэж шийтгүүлж байгаа бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ял дээр өмнөх шүүхийн

¹ Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2009 оны 07 сарын 16-ны өдрийн 217 дугаар шийтгэх тогтоолын хуулбар

² Дархан Уул аймаг дахь Сум дундын шүүхийн 2010 оны 02 сарын 23-ны өдрийн 51 тоот шийтгэх тогтоолын хуулбар

³ Дорноговь аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн 2010 оны 10 сарын 05-ны өдрийн 106 тоот шийтгэх тогтоолын хуулбар

шийтгэх тогтоолоор оногдуулсанаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно.” гэж заасныг хамтад нь журамлаж шийдвэрлэж байгаа нь ялтны эрхийг зөрчихөд хүргэж байна. Дээрх тохиолдолд Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д заасан журмыг хэрэглэж ял оногдуулаад дараа нь Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан журмыг хэрэглэх байтал нь Эрүүгийн хуулийн энэ зохицуулалтуудыг агуулгын хувьд ижил мэт ойлгож практикт хэрэглэж байгаа нь хуулийн заалтыг буруу ойлгож хэрэглэх ингэснээр хүний эрхийг зөрчих эсхүл ял завшуулах боломжийг олгож байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

2. Гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт

Өөрийн орны “Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудал”-ыг боловсронгуй болгох арга замыг судалж буйн хувьд бусад улсад болон олон улсын хэмжээнд энэ асуудлыг хэрхэн зохицуулж буйг судлах нь зайлшгүй тул энэхүү үндэслэлээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/, Япон Улсын болон Дэлхийн эрүүгийн загвар хуулийн зохицуулалтыг энэ хэсэгт авч үзлээ.

1.ХБНГУ-ын зохицуулалт: Тус улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 3-р бүлгийн 2-р хэсэг 53-р зүйлд хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлыг зохицуулжээ.

Тус зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Хэд хэдэн гэмт хэрэг үйлдэж, тэдгээрт нэгэн зэрэг ял шийтгүүлж байгаа бөгөөд тус хэрэгт хэд хэдэн эрх чөлөөг хязгаарлах⁴ ял болон хэд хэдэн торгох ял оногдуулж байгаа тохиолдолд ялыг нэгтгэнэ” гэжээ. ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн дагуу хорих ялыг бүх насаар нь буюу тодорхой хугацаагаар оногдуулж болно. Тодорхой хугацаагаар хорих ялын доод хязгаар нь нэг сар, дээд хязгаар нь 15 жил байна⁵. Гэхдээ нийлмэл гэмт хэрэгт оногдуулах тодорхой хугацаагаар хорих ялын нийт хугацаа 15 жилээс их байж болно⁶.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд зааснаар зөвхөн аль нэг хэрэгт нь хугацаагүй хорих ял оногдуулсан тохиолдолд хөнгөн ялыг хүндэд нь багтаан нэгтгэх журам үйлчилдэг байна.

2.Япон улсын зохицуулалт: Япон улсынЯлын тухай хуульд нийлмэл гэмт хэргийг тодорхойлж, хэд хэдэн гэмт хэрэгт хэрхэн ял оногдуулах талаар зохицуулжээ.

Тус хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гараагүй 2-оос дээш гэмт хэргийг нийлмэл гэмт хэрэг гэнэ” хэмээн тодорхойлсон бөгөөд 46 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар “Нийлмэл гэмт хэргийн доторх нэг гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах тохиолдолд өөр ял оногдуулахгүй. Харин Эд хөрөнгө хураах ял үүнд хамаарахгүй. Нийлмэл гэмт хэргийн доторх нэг гэмт хэрэгт хугацаагүй хорих ял эсхүл нээлттэй хорих ял ногдуулах тохиолдолд өөр ял ногдуулахгүй. Харин торгох, торгууль болон эд хөрөнгө хураах ял үүнд хамаарахгүй” байна. Нийлмэл гэмт хэргийн доторх хоёроос дээш гэмт хэрэгт хугацаатай хорих ял эсхүл баривчлах ял ногдуулах тохиолдолд гэмт хэрэгтэнд хамгийн хүнд гэмт хэрэгт тогтоосон ялын үргэлжлэх хугацаанд уг хугацааны 2-ний 1-ийг нэмсэнийг ялын үргэлжилэх хугацаа гэж үзнэ. Харин тус тусын гэмт хэрэгт

⁴ Freiheitsstrafe — Хорих ял /Хугацаатай болон хугацаагүй/

⁵ ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйл. <http://www.iuscomp.org/gla/statutes/StGB.htm>

⁶ ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 54 дүгээр зүйл. <http://www.iuscomp.org/gla/statutes/StGB.html>

тогтоосон ялын үргэлжлэх хугацааны нийлбэрээс илүү байж болохгүй⁷ гэжээ.

Торгох ялыг бусад ялтай нэгтгэж болно. Нийлмэл гэмт хэргийн доторх 2-оос дээш гэмт хэрэгт торгох ял ногдуулах тохиолдолд тус тусын гэмт хэрэгт тогтоосон торгох ялын хэмжээний нийлбэрээс хэтрэхгүй байна. Нийлмэл гэмт хэргийн доторх хүнд гэмт хэрэгт эд хөрөнгө хураах ял ногдуулахгүй тохиолдолд ч, бусад гэмт хэрэгт эд хөрөнгө хураах шаардлага байвал нэмж ногдуулж болно. Хоёроос дээш эд хөрөнгө хураах ялыг нэгтгэнэ⁸. Нэг үйлдэлт хоёроос дээш гэмт хэрэгт хамаарагдах, эсхүл гэмт хэргийн арга болон үр дүн болох үйлдэл нь өөр гэмт хэрэгт хамаарах тохиолдолд хамгийн хүнд гэмт хэрэгт нь ял шийтгэнэ⁹.

3.Дэлхийн эрүүгийн загвар хуулийн зохицуулалт¹⁰:

Энэхүү загвар хуулийн Ерөнхий ангийн 52 дугаар зүйлд хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлыг зохицуулсан:

52-р зүйл: хоёр болон түүнээс дээш гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах тухай

1.Хоёр болон түүнээс дээш гэмт хэрэгт ял шийтгэгдвэл гэмт хэрэг тус бүрт ял оногдуулсны дараа тэдгээрийг нэмж нэгтгэнэ.

2.Нэмж нэгтгэсэн ял нь оногдуулсан ял тус бүрийн дээд хэмжээнээс илүү байна. Гэхдээ нийт нэмж нэгтгэсэн ялын дээд хэмжээнээс илүүгүй байна. Хорих ялын хувьд нэмж нэгтгэсэн ч 30 жилээс илүүгүй байна.

3.Хорих ялын хувьд шүүхээс оногдуулсан ял тус бүр нь 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял оногдуулсан тохиолдолд нэмж нэгтгэсэн ялын хугацаа 10 жилээс хэтрэхгүй байна.

4.Сүүлийн 3 эрүүгийн зөрчилд тус бүрд нь 15 жилээс дээш хорих ял оноосон тохиолдолд бүх насаар нь хорих нийлмэл ял оноох ба бүх насаар нь хорих ял оногдуулах тусгайлсан нөхцөл нь хүндрүүлэх нөхцөл байдал илэрсэн байх нөхцөл юм.

Тайлбар

1-р догол мөр: 2 болон түүнээс дээш гэмт хэрэгт ял шийтгэгдсэн бол зөрчилд тус бүрт хорих ялын хугацааг тусад нь авч үзнэ. 41-р зүйлд тодорхойлсон процессын дагуу эрүүгийн зөрчил тус бүрийг тусад нь авч үзнэ.

2-р догол мөр: Загвар хуулийн зохицуулалтаар, хоёр болон түүнээс дээш гэмт хэрэгт ял шийтгүүлвэл шүүх бүх эрүүгийн зөрчилд нь нийлмэл ял оногдуулдаг. Уг нийлмэл ял нь шүүхээс оногдуулсан ял тус бүрийн хуулиар тогтоосон дээд хэмжээнээс илүү байх ёстой гэхдээ 30 жилээс илүүгүй байна. Загвар хуулийн төслийг боловсруулагчдын тогтоосон 30 жилийн хугацаа нь 4-р догол мөрд зааснаас бусад тохиолдолд гэм буруутай этгээдэд ногдуулж болох нийлмэл ялын дээд хэмжээ юм. Нийлмэл ялын дээд хэмжээнд тогтоосон хязгаарлалтыг хорих ялд хэрэглэхээс гадна өөр ялуудад тухайлбал, эрх чөлөөний зарим хэсгийг хасах ял(semiliberty), олон нийтийн үйлчилгээний ялд мөн нэмэлт ялд тухайлбал, expul-

⁷ Япон улсын Ялын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

⁸ Япон улсын Ялын тухай хуулийн 48 дугаар зүйл <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

⁹ Япон улсын Ялын тухай хуулийн 54 дүгээр зүйл <http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

¹⁰ Model Codes for Post-conflict. Criminal Justice Model Criminal code. Vivienne O'Connor and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of Law. W,P,L 2007

sion of non-national-Улсын иргэншлээс хасах ялд хэрэглэдэг.

3-р догол мөр: энэ догол мөрийн зорилго бол хэд хэдэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд гэхдээ шүүхээс ял тус бүрт доогуур ял оноосон этгээдийн зөрчил тус бүрт нь нийцэхгүй хүнд нийлмэл ял оногдуулахаас сэргийлж баталгаажуулахад оршино.

4-р догол мөр: гэмт хэрэгтэнд шүүхээс 15 эсвэл түүнээс дээш хугацаатай хэд хэдэн хорих ял оногдуулсан тохиолдолд шүүх бүх насаар нь хорих нийлмэл ял оногдуулахаар сонгож болно.

ХБНГУ-ын хувьд хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмыг эрүүгийн хуульдаа хуульчилсан. Ингэхдээ үндсэн ялын төрөл болох эрх чөлөө хязгаарлах, торгох ялыг хэрхэн нэгтгэх талаар заажээ. Эрх чөлөө хязгаарлах болон торгох ялыг оногдуулвал ялыг нэгтгэнэ. Эрх чөлөө хязгаарлах болон торгох ялыг нэг зэрэг оногдуулвал нэгтгэж торгох ял оногдуулна. Нэмэгдэл ял болох эд хөрөнгө хураах ялыг хэд хэдэн гэмт хэрэгт оногдуулах журмыг хуульчилсан. Ингэхдээ эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялын чанартай болон, нэгтгэх заалт оруулжээ. ХБНГУ-ын ЭХ-ийн дагуу хорих ялыг бүх насаар нь буюу тодорхой хугацаагаар оногдуулж болно. Тодорхой хугацаагаар хорих ялын доод хязгаар нь нэг сар, дээд хязгаар нь 15 жил байхаар заажээ. Гэхдээ нийлмэл гэмт хэрэгт оногдуулах тодорхой хугацаагаар хорих ялын нийт хугацаа 15 жилээс их байж болно. ХБНГУ-ын хувьд зөвхөн аль нэг хэрэгт нь хугацаагүй хорих ял оногдуулсан тохиолдолд хөнгөн ялыг хүндэд нь багтаан нэгтгэх журам үйлчилдэг байна. Мөн тус улсад цаазаар авах, хугацаагүй хорих ял оногдуулах гэмт хэрэгт ял нэгтгэдэггүй болно. Хэд хэдэн эрүүгийн хэрэгт хамгийн урт хугацаагаар хорих ялыг оногдуулна. Өөрөөр хэлбэл хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулахдаа оноож болох хамгийн өндөр ялтай ялыг оногдуулахаар хуульчилжээ.

Япон улсын ялын тухай хуульд нийлмэл гэмт хэрэгт ял оногдуулах асуудлыг ялын тухай хуулиндаа нэлээн дэлгэрэнгүй байдлаар оруулж өгсөн онцлогтой байна. Нийлмэл гэмт хэргийн тодорхойлолтыг хуулиндаа оруулж өгсөн бөгөөд ял нэгтгэхэд тавих хязгаарлалт, ял нэгтгэх журмуудыг ял тус бүрээр нь нарийвчлан зааж өгснөөрөө онцлогтой байна.

3. Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь:

Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын гэрээ, конвенцийн агуулга, зарчимд нийцүүлэх нөгөө талаас нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтүүдээс улбаалан 2002 онд эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан билээ. Гэсэн хэдий ч хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудлын хүрээнд зарчмын шинжтэй, дорвитой өөрчлөлт төдийлөн ороогүй нэн ялангуяа эрх зүйн зохицуулалтын хувьд өмнөх хуулийн цээрлүүлэх үзэл баримтлал хадгалагдан үлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй.

Дэлхий дахиныг хамарсан даяарчлал, нийгэм эдийн засагт гарч буй эерэг, сөрөг өөрчлөлтийн үр дүнд эрүүгийн эрх зүй хөгжлийн шинэ үе шатанд шилжин орж байна. XXI зууны эхэн үеэс эрүүгийн эрх зүй хэвшиж тогтсон системүүдийн бүтэц, тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарч, үзэл баримтлал, бодлого, чиг хандлагын хувьд шинэчлэгдэж, бүхэлдээ хувьсан өөрчлөгдөж байна¹¹.

Орчин үед эрүүгийн эрх зүйн салбарт гарч буй үндсэн өөрчлөлтүүдийг

¹¹ Баярсайхан, Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй, Улаанбаатар хот, 2012 он

дараахь чиглэлээр авч үзэж болно.¹²

1. Хүнлэг ёсны хандлага
2. Криминализацийн хандлага
3. Интеграцчилалын хандлага

4. Глобалчлалын хандлага. Эдгээрээс хүнлэг ёсны хандлага эрүүгийн эрх зүйд тогтвортой үзэл баримтлал болон хөгжиж байна. Эл хандлагын хүрээнд цаазаар авах ялаас татгалзах, албадан ажил хийлгэх ялаас татгалзах, эд хөрөнгө хураах ялыг хязгаарлах буюу татгалзах, хорих ялын доод хязгаарыг тогтоохоос татгалзах, ялын харгис хэрцгий хэлбэрийг бүр мөсөн устгах, эрх чөлөөг хязгаарлах болон хорих цагдах, баривчлах ялын шинэ хэлбэрүүдийг альтернатив нөхцлөөр тогтоох, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хүрээ хязгаарыг өргөтгөх, насанд хүрээгүй хүмүүсийн эрүүгийн эрх зүйн дэглэмийн уян хатан байдлыг тогтоох, эрүүгийн ба эрүүгийн ял бус хариуцлагын харьцаа хамаарлыг хүнлэг ёсны зарчимд нийцүүлэх зэрэг олон асуудлыг өөртөө багтаах бөгөөд үүнд судлан буй хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудал нь ялын хөнгөрүүлэх нөхцөл байдлын хүрээг өргөтгөж, хөнгөрүүлж буй тохиолдолд хорих ялыг хэрэглэхгүй байх аль болох ял бус хариуцлагыг хүлээлгэх, ялуудыг хооронд нэмэх бус багтаах аргыг хэрэглэх гээд ялын нийгэмшүүлэх онолыг хэрэгжүүлэх асуудлуудыг хамааруулдаг байна.

Эдүгээ эрүүгийн эрх зүйн салбарт глобалчлалын үйл явц хүчтэй өрнөж байгаатай холбоотойгоор дэлхий дахины эрүүгийн загвар хуулиуд батлагдан гарч олон улсын хэмжээнд дагаж мөрдөх ялын бодлогын үзэл баримтлал буй болж байгаагийн илрэл нь 2007 оны эрүүгийн загвар хууль¹³ мөн. Уг хуульд ялыг оногдуулахдаа тухайн хэргийн нийгмийн хор аюул, хууль зөрчсөн байдлын түвшин, хэмжээ, яллагдаж буй этгээдийн засрах боломж болон нийгмийн шударга ёс сэргээгдсэн эсэхийг харгалзан оновчтой шийдэж байх нөхцлүүдийг заажээ.

Түүнчлэн Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн \СНГ\ орнуудын эрүүгийн загвар хуулийг батлан гаргасан бөгөөд уг хуулийн гуравдугаар хэсэгт хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмыг өвөрмөц байдлаар тогтоожээ¹⁴.

Олон улсын дурьдсан жишиг хандлагад нийцүүлэн Монгол Улсын эрүүгийн хуулийг өөрчилж шинэчлэх нэн ялангуяа ялын бодлогод дорвитой өөрчлөлт хийх, түүний дотор хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлыг уян хатан байдлаар өөрчлөх зайлшгүй шаардлага зүй ёсоор тулгарч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Ийнхүү Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг дараах байдалд авч үзье.

А\ . Судалгааны явцад хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах явцад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байсныг авч үзвэл

1. Эрүүгийн хуулийн 6-р зүйлийн 2-т: “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаагийн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн шударга ёсны зарчим хуулийн уг заалттай холбоотойгоор алдагдахад хүрч байна.

¹² Баярсайхан, Д. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, Шударга ёс сэтгүүл, 2010 он, №3

¹³ Model Codes for Post-conflict Criminal Justice Model Code. Vivienne O'Connor and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of Law6 W,P,L. 2007

¹⁴ Модельный уголовный кодекс Содружества Независимных Государств. Рекомендательный законодательный акт. М.1996.

2. Эрүүгийн хуулийн 57-р зүйл, 58-р зүйлийн заалтууд өөр хоорондоо нийцэхгүй байна.

3. Ял оноож байгаа шүүхийн практикийг харахад “хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэг тус бүрт нь тохирсон ял оноож зохих журмаар нэгтгэх ёстой байтал аль нэг хэрэгт хэт хүнд ял оногдуулж бусад ялыг багтааж хялбарчлах нь ялын бодлогод нийцэхгүй буруу практик тогтоож байна”

4. Практикт шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаан болон гадаад орнуудын эрүүгийн эрх зүйн зохицуулалтуудыг судлан үзэхэд хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудлыг төдийлөн хэрэглэдэггүй болох нь харагдсан юм.

Энэ нь эрүүгийн хэм хэмжээний зөрчилдөөнийг буй болгож байгаа бөгөөд энэ нь эцсийн дүндээ хүний эрхийг зөрчих, эсхүл ял завших боломжийг бүрдүүлж байгаа юм.

Нийтлэг эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж буй эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ нь дотооддоо болон бусад салбар эрх зүйн хэм хэмжээтэй ямар нэг зөрчилдөөнгүй системчлэгдсэн байх нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах үндсэн зорилтоо хангахад чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хүний эрхийг хамгаалахын тулд хүний эрх эрх чөлөөнд халддаг эрх зүйн салбар болохын хувьд эрүүгийн эрх зүй нь сайтар боловсруулагдсан, аливаа зөрчилдөөнгүй хэм хэмжээний тогтолцоог бүрдүүлэх ёстой. Энэ утгаараа хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг өөрчилж боловсронгуй болгох, зөрчилдөөнийг арилгах нь хүний эрхийг зөрчихгүй, мөн ял завшуулахгүй байх эрүүгийн эрх зүйн үндсэн зорилгыг хангах нэг гол нөхцөл гэж үзэж байна.

Б\ . Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулахдаа ял оногдуулах нийтлэг зарчмыг удирдлага болгодог хэдий ч энэ нь олонлог гэмт хэргийн хувьд яригддаг учраас өвөрмөц зохицуулалт шаардагддаг. Энэ утгаар давтан, нийлмэл гэмт хэрэгт ял оногдуулах тусгай зарчим шаардлагатай гэж үзэж байна.

В\ . Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох зүйлд “тусгай ангид заасан хэд хэдэн ялыг хамт оногдуулж болохоор” заасан байгаа нь гэмт хэрэгтэн 2-оос 3 төрлийн ял эдлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь ял эдлүүлэх ажиллагаанд бэрхшээл учруулаад зогсохгүй ялтаг уг ялуудыг ямар хугацаанд эдэлж дуусах нь тодорхойгүй, магадгүй насан туршдаа дээрх ялуудыг эдэлсээр байх боломжтой мэт ойлголтыг төрүүлж байна. Иймд эл ойлголтыг хуульчлахдаа хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмыг тодорхой болгож практикт хэрэглэхэд ямар нэг хүндрэл бэрхшээл учруулахгүй байхуйцаар тогтоох шаардлага тулгарч байна. Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулахад нэмэгдэл ялуудыг хэрхэн нэгтгэх асуудал, түүнчлэн Эрүүгийн Эрх Зүйн хүмүүнлэг тогтолцоонд тулгуурлан гэмт хэрэг тус бүрд оногдуулсан ялыг бүгдийг нэмж нэгтгэхийн оронд багтаах, нэмэх аргуудыг хослуулан хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна. Гэмт этгээд ял завших, улмаар шударга ёсны зарчим алдагдах боломж бүрдэх учир хуулийн зохицуулалтыг сайтар судалж боловсруулах нь зүйтэй юм. Нэн ялангуяа ял тус бүрийг нэмж нэгтгэх, багтаах аргыг хэрэглэхийн тулд ялыг дүйцүүлэх бүх боломжуудыг нэг бүрчлэн тогтоох шаардлагатай. Ингэснээр ялтныг ял завшихгүй байх эсхүл хүний эрхийг зөрчихгүй байх боломж бүрдэх юм.

ДҮГНЭЛТ

Практикийг судлан үзэхэд Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмыг хэрэглэж хэвшсэн мэт байгаа боловч энэ зүйл заалтуудыг өөр өөрөөр хэрэглэж хүний эрхийг зөрчих, ял завшуулах дутагдал гарсаар байгаа мөн давж заалдах шатны шүүхээс хууль буруу хэрэглэсэн үндэслэлээр хэрэгт өөрчлөлт орох, хүчингүй болгох асуудал цөөнгүй байгаа нь тогтоогдсон юм. Гадаад орнуудын хууль тогтоомжид тусгагдсан байдлыг судлан үзэхэд ял нэгтгэхэд тавих хязгаарлалт, ял нэгтгэх журмуудыг ял тус бүрээр нь нарийвчлан зааж өгснөөрөө онцлогтой харагдаж байна. Өөр нэг онцлог нь БНХАУ-ын Эрүүгийн хуульд л хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудлыг хуульчилжээ. Харин харьцуулсан бусад улс болох ХБНГУ, Япон болон Дэлхий дахины Эрүүгийн загвар хуульд хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудлыг хуульчлаагүй, хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах журмаар зохицуулдаг нь харагдаж байна. Эрүүгийн хуулийн хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах, хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах гэсэн зүйл заалтуудыг агуулгын хувьд ижил мэт ойлгож практикт хэрэглэж байгаа нь хуулийн заалтыг буруу ойлгож хэрэглэх ингэснээр хүний эрхийг зөрчих эсхүл ял завшуулах боломжийг олгож байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

САНАЛ

Эцэст нь хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын хүрээнд:

1. Юуны өмнө эрүүгийн ялын бодлогыг олон улсын нийтлэг жишиг хандлагад нийцүүлэн эрүүгийн эрх зүйд тэргүүлэх чиглэл болон хөгжиж буй хүмүүнлэг тогтолцооны хүрээнд дорвитой өөрчлөлт хийх шаардлагатайг онцолж байна.

2. Дээрхтэй уялдаатайгаар ял оногдуулах, ялаас чөлөөлөх зэрэг ял хариуцлагатай холбоотой олон асуудлыг гуманизацийн \хүмүүнлэг\ хүрээнд өөрчлөх боломж бүрдэнэ. Тухайлбал ялыг нэгтгэхдээ нэмж бус багтаан хэрэглэх нь эл тогтолцооны салшгүй бүрэлдүүн хэсэг мөн.

3. Судалгааны явцад ажиглагдсан эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний дотоод зөрчилдөөнийг арилгах зайлшгүй шаардлагатай. Энэхүү зөрчилдөөн нь ялыг нэгтгэх асуудлын хүрээнд ял завшуулах, хүний эрхийг зөрчих боломжийг бүрдүүлж байгаа юм.

4. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах зохицуулалт нь Хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах хуулийн заалттай нийцэхгүй, ял оногдуулахад бэрхшээлтэй байдал үүсгэж байгааг харгалзан, гадаад орнуудын жишиг хандлагад нийцүүлэн хуулийн бие даасан зүйлээс хасах, хэд хэдэн гэмт хэрэгт ял оногдуулах асуудалтай нэгтгэн зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.